# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 5 (338)

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:**

- *Ардын болон гавьяат цол хүртээсэн тухай*

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:**

- *Барилга шилжүүлэх тухай*
- *Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай*
- *Төлөвлөгөө батлах тухай*

**Улсын Их Хурлын Тамгын газар**
**Улаанбаатар хот**
**2004 он**

#### ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2004 оны хоёрдугаар сарын 5 № 5 (338)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

| | | | |
|---|---|---|---|
| 49. | Балжиннямын Жамъяндагвад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай | Дугаар 178 | 49 |
| 50. | Хаваны Байгобылд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 179 | 50 |
| 51. | Загдын Шаравт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 180 | 50 |
| 52. | Лувсангийн Доржсамбууд Монгол Улсын малын гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 181 | 50 |
| 53. | Долгоржавын Сайн-Эрд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай | Дугаар 182 | 50 |
| 54. | Чимэддоржийн Тэрбишт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай | Дугаар 183 | 51 |
| 55. | Шагдаржавын Магванд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 184 | 51 |
| 56. | Жанчивын Раднаабазарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай | Дугаар 185 | 51 |
| 57. | Нямаагийн Туулайхүүд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 186 | 51 |

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

| | | | |
|---|---|---|---|
| 58. | Барилга шилжүүлэх тухай | Дугаар 242 | 52 |
| 59. | Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Дугаар 243 | 52 |
| 60. | Төлөвлөгөө батлах тухай | Дугаар 245 | 52 |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр — Дугаар 178 — Улаанбаатар хот

**Балжиннямын Жамъяндагвад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээх тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж Монгол улсад бүжгэн жүжгийн урлагийг үүсгэж хөгжүүлэх, үндэсний болон дэлхийн сонгодог бүжгэн жүжгүүдийг чадварлаг найруулан тавьж үзэгчдийн хүртээл болгох, жүжигчдийн ур чадвар, мэргэжлийн түвшинг ахиулахад оруулж байгаа үнэтэй хувь нэмрийг нь үнэлж Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын уран сайхны удирдагч Балжиннямын Жамъяндагвад Монгол Улсын ардын жүжигчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

**Хаваны Байгобылд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлийн технологи үйл ажиллагаа болон хөдөлмөрийн хамт олныг оновчтой зохион байгуулан үйлдвэрлэлийн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж тус үйлдвэрийн баяжуулах фабрикийн бутлах, тээвэрлэх хэсгийн дарга Хаваны Байгобылд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

**Загдын Шаравт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрт олон жил үр бүтээлтэй ажиллаж шинэ техник, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэн, техникийн үйлчилгээ, засварыг цаг хугацаанд нь чанартай хийлгэж, техникийн бэлэн байдал, үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагааг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж тус үйлдвэрийн автотээврийн байгууллагын автозасварын газрын дарга Загдын Шаравт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

**Лувсангийн Доржсамбууд МонголУлсын малын гавьяат эмч цол хүртээх тухай**

Хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж мал сүргийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчилж эдгэрүүлэх, малын эм бэлдмэлийг үйлдвэрлэх ажлыг чадварлаг зохион байгуулж, үйлдвэрлэлд шинэ техник технологи нэвтрүүлэн, бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэх, чанар, үр ашгийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Биокомбинатын дарга Лувсангийн Доржсамбууд Монгол Улсын малын гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

**Долгоржавын Сайн-Эрд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай**

Барилгын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж монголын орчин үеийн хот байгуулалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөгжүүлж, хот суурин газрын ерөнхий төлөвлөгөөний үндэслэлийг боловсронгуй болгох, хот байгуулалтын төрийн бодлогын үндсэн зарчмуудыг тодорхойлох, хүн амын нутагшилт, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулах, хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Хот байгуулалт" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Долгоржавын Сайн-Эрд Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

**Чимэддоржийн Тэрбишт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай**

Барилгын байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж хариуцсан бригадаа чадамгай зохион байгуулан үйлдвэрлэлийн төлөвлөгөөт даалгаврыг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын олон барилгыг чанартай барьж ашиглалтад оруулах, залуу барилгачдыг ажилд нь дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дархан-Уул аймгийн "Дархан хөлөг" ХХК-ийн өрөг үгсрагч, бригадын дарга Чимэддоржийн Тэрбишт Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

**Шагдаржавын Магванд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Төрийн болон төрийн бус байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж биеийн тамир спортын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, материаллаг баазыг бэхжүүлэх, тамирчдын ур чадвар, амжилтыг дээшлүүлж тив, дэлхийн тавцанд өрсөлдөх хэмжээнд хүргэх, өсвөр үе, залуучуудад олимпийн хөдөлгөөнийг сурталчилж дэлгэрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Олон улсын олимпийн хорооны гишүүн Шагдаржавын Магванд Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

**Жанчивын Раднаабазарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшин хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах болон эрдэм судлалын хөгжилд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн зөвлөх эмч Жанчивын Раднаабазарт Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2003 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 186

Улаанбаатар хот

**Нямаагийн Туулайхүүд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Мэргэжлийн урлагийн байгууллагуудад олон жил үр бүтээлтэй ажиллаж үндэсний болон дэлхийн сонгодог хөгжмийн зохиолчдын бүтээл, концертуудыг мэргэжлийн өндөр түвшинд удирдан тоглуулж, дуурь, бүжгэн жүжгийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын ерөнхий удирдаач Нямаагийн Туулайхүүд Монгол Улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр** **Дугаар 242** **Улаанбаатар хот**

**Барилга шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байгаа Төрийн өмчийн 11 дүгээр байрыг Хүүхдийн төлөө үндэсний газрын балансад шилжүүлэхийг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Эрүүл мэндийн сайд бөгөөд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын үүрэг гүйцэтгэгч П.НЯМДАВАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр** **Дугаар 243** **Улаанбаатар хот**

**Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**

Хөдөлмөрийн тухай хуулийн 111.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тахир дутуу буюу одой хүн ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх ажлын байрны төлбөрийг ажиллуулбал зохих орон тоо тутамд хөдөлмөрийн хөлсний нэг сард ногдох доод хэмжээтэй тэнцүү байхаар тогтоосугай.

2. Бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд тахир дутуу буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхий менежер нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төлбөрийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 137 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Эрүүл мэндийн сайд бөгөөд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын үүрэг гүйцэтгэгч П.НЯМДАВАА**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2003 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр** **Дугаар 245** **Улаанбаатар хот**

**Төлөвлөгөө батлах тухай**

Улсын Их Хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын эхний үе шат (2003-2008 он)-д хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор батлапсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр болон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгах, гадаад, дотоодын байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар хэрэгжүүлэн ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөний биелэлт, үр дүнг нэгтгэн жил бүрийн IY улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд үүрэг болгосугай.

**Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР**

**Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.НАСАНЖАРГАЛ**

*Засгийн газрын 2003 оны 245 дугаар тогтоолын хавсралт*

ТӨРӨӨС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2003-2008 он/

| Бодлогын зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх байгууллага | Төрөөс дэмжлэг үзүүлэх зардлын хэмжээ /сая.төг/ | Зардлын санхүүжилт | Үнээс /сая.төг/ 2004 онд | 2005 онд | 2006 онд | 2007 онд | 2008 онд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Бизнесийн таатай орчин бүрдүүлэх, үйлдвэрлэлийн бүтээмж чадавхийг нэмэгдүүлэх** | | | | | | | | | |
| Нэг. Салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох | 1.1. Малчин өрх, фермерийн аж ахуйн эрх зүйн байдлыг тодорхой болгох, | ХХААЯ, ХЗДХЯ | | Төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын урсгал төсвийн хүрээнд санхүүжигдэнэ. | x | x | | | |
| | 1.2. Малыг халдварт өвчин, ган, зудаас хамгаалахад төр, иргэний оролцоо, үүргийг хуулиар зааглан тодруулах, | ХХААЯ, ХЗДХЯ | | | x | x | | | |
| | 1.3. Малын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, | СЭЗЯ, ХХААЯ, ХЗДХЯ | | | x | | | | |
| | 1.4. Бэлчээр эзэмшүүлэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, | БОЯ, ХХААЯ, ХЗДХЯ | | | | x | x | | |
| | 1.5. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоож, эрх зүйн зохицуулалтад оруулах, | Аймгийн ИТХ, ЗД | | | x | x | x | x | x |
| | 1.6. Эрчимжсэн мал аж ахуйг газар тариалан, тэжээл үйлдвэрлэлтэй зохистой хослон эрхлэхтэй холбогдсон стандарт, нормативыг боловсруулж мөрдүүлэх, | ХХААЯ, СХЗТ | | | | x | x | | |
| | 1.7. Мал аж ахуй эрхлэгчдээс авах бэлчээрийн төлбөрийн хэмжээг малын ашиг шимийн чиглэл, бүсийн ялгавартайгаар тогтоох, | БОЯ, ХХААЯ, ХЗДХЯ | | | | x | | | |
| | 1.8. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартыг батлуулж, мөрдүүлэх | ХХААЯ, СХЗТ | | | x | | | | |
| | 1.9. Худаг, уст цэгийн эзэмшил, ашиглалтын эрх зүйн орчинг бүрдүүлэх, | БОЯ, ХХААЯ, ХЗДХЯ | | | x | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.10 Тариалангийн газрын ашиглалтыг сайжруулах, хөрсний чанар байдалд хяналт тавих, усалгаатай газар тариалангийн зориулалтаар атар газар эзэмших, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд тариалангийн газрыг ашиглуулах, тэжээлийн ургамал тарих сонирхолтой гадаадын иргэн, аж ахуйн нэгжид газрыг хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах зэрэг асуудлын эрх зүйн үндсийг бүрдүүлэх | ХХААЯ, ХЗДХЯ | | | x | | | | |
| | 1.11 Биологийн идэвхт хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахтай холбогдсон эрх зүйн орчин бүрдүүлэх, | ХХААЯ, ХЗДХЯ | | | x | | | | |
| Хоёр. Дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн ашиглалтыг сайжруулах | 2.1 Эрчимжсэн мал аж ахуй, усалгаатай тариалан болон мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах орчин үеийн дэвшилттэй техник, технологи бүхий жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэхэд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламж, зээлийг түлхүү чиглүүлэх зорилгоор хандивлагчидтай идэвхтэй хамтран ажиллах, | ГХЯ, СЭЗЯ, ХХААЯ, ҮХЯ | | Төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын урсгал төсвийн хүрээнд санхүүжигдэнэ. | x | x | x | x | x |
| | 2.2 Хөдөө аж ахуйн техникийн лизингийн үйлчилгээ нэвтрүүлэх боломж, арга замыг судалж, туршин нэвтрүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | | | x | x | | | |
| | 2.3 Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа дотоод, гадаадын төсөл, хөтөлбөрүүдийн уялдааг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ авах, | ХХААЯ, ГХЯ, СЭЗЯ | | | x | x | x | x | x |
| | 2.4 Экспортын чиг баримжаатай жижиг, дунд үйлдвэрийг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийн нөөцтэй ойр байршуулан хөгжүүлж, боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, | ХХААЯ, ҮХЯ | | | x | x | x | x | x |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.5 Хүнсний хангамжийг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр гадаадын буцалтгүй тусламжийн хуримтлалын сангаас олгосон зээлийн ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, эргэн төлөлт, өр авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, | СЭЗЯ, ХХААЯ, ГХЯ | | | x | x | x | x | x |
| | 2.6 Дундын хоршоогоор дамжуулан бөөний худалдааны үйл ажиллагаа явуулах боломжийг 8-аас доошгүй аймагт турших, | ҮХЯ, ХХААЯ, СЭЗЯ | | | x | x | x | x | x |
| Гурав. Татвар, зээл, хөрөнгө оруулалт, гадаад худалдааны уян хатан бодлого баримтлах | 3.1 Бараа, бүтээгдэхүүний импортын татварын уян хатан бодлого явуулж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд шаардлагатай үед дотоодын зах зээлээ хамгаалах арга хэмжээ авах, | СЭЗЯ, ХХААЯ, ҮХЯ | 0.0 | Төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын урсгал төсвийн хүрээнд санхүүжигдэнэ. | x | x | x | x | x |
| | 3.2 Арвин ашиг шимт мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл үр, үржлийн мал, ажил, үйлчилгээний багаж, газар тариалангийн усалгааны тоног төхөөрөмж зэргийг импортлоход нэмүү өртгийн татвар болон гаалийн татвараас чөлөөлөх асуудлыг судалж боловсруулах, | СЭЗЯ, ХХААЯ | 0.0 | | x | | | | |
| | 3.3 Шинээр усалгаатай тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэж байгаа иргэн, хуулийн этгээдийг эхний 3 жил орлогын албан татвараас чөлөөлөх боломж, үндэслэлийг судлан боловсруулах, | СЭЗЯ, ХХААЯ | 0.0 | | | x | | | |
| | 3.4 Хүүхдийн хоол тэжээл болон бордоо, ургамал хамгааллын бодис, малын эм, бэлдмэл дотоодод үйлдвэрлэхэд татварын хөнгөлөлт үзүүлэх шаардлага, үндэслэлийг судлах, | СЭЗЯ, ХХААЯ | 0.0 | | | | x | | |
| | 3.5 Хөдөө аж ахуйн түүхий эд, өргөн хэрэглээний бараа, материал, сэлбэг, техник хэрэгслийн бөөний худалдааны сүлжээ байгуулахад дэмжлэг үзүүлэх, | СЭЗЯ, ҮХЯ, ХХААЯ | 850.0 | Улсын төсвөөс | 850.0 | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3.6 Хоршоодоор төрөөс захиалгаар бүтээгдэхүүн үйлдвэрлүүлэх, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх замаар тэдний эдийн засаг, санхүүгийн чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, НХХЯ, ҮХЯ, СЭЗЯ | 0.0 | | x | x | x | x | x |
| | 3.7 Банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж зээлийн хоршооны үйлчилгээг хөдөөд өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, | СЭЗЯ, ХХААЯ | | | x | x | x | x | x |
| | 3.8 Загвар хоршоо, дундын хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ, ҮХЯ | 0.0 | | x | x | x | x | x |
| | **Дүн** | | **850.0** | | **850.0** | **0.0** | **0.0** | **0.0** | **0.0** |
| **Мал аж ахуйн талаар:** | | | | | | | | | |
| Нэг. Монгол малын тэсвэрт чанарыг бататган биологийн боломжийг нь бүрэн ашиглах, зүй бусын хорогдол, хээл хаялт, сувайралтыг багасгах замаар үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх | 1.1 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэж байгаа бүс, нутгуудад зохиомол хээлтүүлгийн байнгын болон явуулын 35-аас доошгүй цэг байгуулан үйлчилгээг өргөтгөх, | ХХААЯ | 225.0 | Улсын төсвөөс | 75.0 | 100.0 | | | |
| | | | | Гадаадын тусламжаас | 25.0 | 25.0 | | | |
| | 1.2 Сайжруулагч үүлдэр, омгийн малын цөм сүрэг бүрдүүлэх, аж ахуйн нэгж, иргэдийг сонгон шалгаруулах замаар үржлийн хээлтүүлэгч бойжуулуулах, тэдгээрт дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 400.0 | Улсын төсвөөс | 180.0 | 160.0 | | | |
| | | | | Гадаадын зээлээс | | | 20.0 | 20.0 | 20.0 |
| | 1.3 Зарим үүлдэр, омгийн малын удмын санг сэргээх зорилгоор өндөр ашиг шимтэй үржлийн мал, амьтан, үр, хөврөл үр импортлож үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, | ХХААЯ, ҮХЯ | 1000.0 | Гадаадын тусламжаас | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 |
| | 1.4 Бог малын хээлтүүлэгчийг сумын мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний нэгжийн мэдэлд шилжүүлэн стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчээр хангах арга хэмжээ авах, | ХХААЯ, СЭЗЯ | 170.0 | Гадаадын тусламжаас | 20.0 | 40.0 | 30.0 | 50.0 | 30.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хоёр . Адууг уналга-эдэлгээ, махны; үхрийг мах, сүүний; тэмээг ачлага-эдэлгээ, ноос, сүүний; хонийг мах, нооcны; ямааг ноолуур, сүүний чиглэлээр зонхилон үржүүлэхийн зэрэгцээ боломжтой бүс нутагт гахай, шувуу, зөгий, туулайны зэрэг уламжлалт бус аж ахуйг хөгжүүлэх | 2.1 Бүсийн тулгуур төвүүдийн ойролцоо махны чиглэлийн адуу үржүүлж, олон улсын эрүүл ахуй, ариун цэврийн стандартын шаардлагад нийцсэн адууны махны экспортыг бий болгох, | ХХААЯ, ҮХЯ, ТББ | 500.0 | Гадаадын тусламжаас | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| | 2.2 Монгол тэмээний сүүн бүтээгдэхүүн, ноос, тэмээн спорт, аялал жуулчлалын талаар гадаадад сурталчлан зах зээлийг өргөжүүлэх арга хэмжээ авах, | ХХААЯ, ДБЯ | | | x | x | x | x | x |
| | 2.3 Тэмээ, хонины ноос, ямааны ноолуур боловсруулах үйлдвэрүүдийг урамшуулан дэмжих арга замыг судлаж шийдвэрлүүлэх, | ҮХЯ, ХХААЯ | 150.0 | Гадаадын тусламжаас | 30.0 | 30.0 | 30.0 | 30.0 | 30.0 |
| Гурав. Бүсийн тулгуур төвүүд болон тариалангийн бүс нутагт эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх | 3.1 Бүсийн төв, тулгуур хотуудын ойролцоо болон газар тариалангийн бүсийг түшиглэн эрчимжсэн мал аж ахуйн загвар фермерийн аж ахуйг үүсгэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 660.0 | Улсын төсвөөс | 50.0 | 70.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 30.0 | 60.0 | 50.0 | 50.0 | 50.0 |
| | 3.2 Бүсийн тулгуур төвүүдийн болон Увс, Говь-Алтай аймгийн мал эмнэлгийн лабораторийг бэхжүүлэн тэдгээрийн шинжилгээний чадавхийг сайжруулах, | ХХААЯ, СЭЗЯ | 260.0 | Гадаадын тусламжаас | 200.0 | 60.0 | | | |
| | 3.3 Мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд химийн бодисын үлдэгдэл тодорхойлох лаборатори байгуулах төсөл боловсруулж шийдвэрлүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ, | 498.0 | Гадаадын тусламжаас | 150.0 | 230.0 | 118.0 | | |
| Дөрөв. .Мал сүргийг эрүүлжүүлэх, халдваргүйжүүлэх эмчилгээ, | 4.1 Ховд, Баян-Өлгий болон Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймгийн хилийн сумдын малд шүлхий өвчнөөс сэргийлэх вакцинжуулалт хийх, | ХХААЯ, СЭЗЯ | 4450.0 | Улсын төсвөөс | 1450.0 | 1000.0 | 1000.0 | 500.0 | 500.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| оншилгооны чадавхийг дээшлүүлэх | 4.2 Мэлзэн өвчний тандан судалгааг хийсний үндсэн дээр уг өвчнөөр тайван болохыг олон улсын байгууллагын түвшинд баталгаажуулах, вакцин хэрэглэдэггүй тайван орны жагсаалтад орох арга хэмжээ авах, | ХХААЯ, | 60.0 | Гадаадын тусламжаас | | 30.0 | 30.0 | | |
| | 4.3 Малын эм бэлдмэл шалгах Улсын нэгдсэн лабораторийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, шинжилгээний чадавхийг сайжруулах талаар төсөл хэрэгжүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 700.0 | Гадаадын тусламжаас | 150.0 | 450.0 | 100.0 | | |
| | 4.4 Мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээний чанар, үр дүнг дээшлүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 14650.0 | Улсын төсвөөс | 3150.0 | 3000.0 | 3000.0 | 3000.0 | 2500.0 |
| | 4.5 Мал эмнэлгийн эмчлэн сэргийлэх арга хэмжээний үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 4596.0 | Улсын төсвөөс | 696.0 | 1000.0 | 1000.0 | 1000.0 | 900.0 |
| | 4.6 Биокомбинатын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, эм бэлдмэлийн үйлдвэрлэлийг олон улсын стандартын шаардлагын түвшинд хүргэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 2150.0 | Гадаадын тусламжаас | | 550.0 | 550.0 | 600.0 | 450.0 |
| | 4.7 Орчин үеийн технологитой малын эмийн үйлдвэр байгуулахад дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг чиглүүлж дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 300.0 | Гадаадын тусламжаас | | 100.0 | 100.0 | 100.0 | |
| Тав. Малын удмын санг хамгаалах, сайжруулах | 5.1 Нэн ховордож, тоо толгой нь цөөрч байгаа үүлдэр, омгийн мал болон устаж үгүй болж байгаа амьтны үрийг авч шинэ технологиор хөлдөөн хадгалж, гений санд баяжилт хийх, | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 13.0 | Улсын төсвөөс | 1.5 | 1.5 | | | |
| | | | | Гадаадын тусламжаас | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 |
| | 5.2 Малын удмын сангийн үндэсний төвд эсэл эс хадгалах лаборатори шинээр байгуулан ажиллуулах, | ХХААЯ | 28.0 | Улсын төсвөөс | 0.0 | 10.0 | 10.0 | 8.0 | |
| | 5.3 Гойд ашиг шимт үүлдрийн мал шалгаруулах үзэсгэлэн, худалдааг бүсчилэн зохион байгуулах, | ХХААЯ, ҮХЯ | 55.0 | Улсын төсвөөс | 6.0 | 6.0 | 6.0 | 6.0 | 6.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зургаа. Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах | 6.1 Инженерийн хийцтэй 4000 худагт засвар, шинэчлэлт хийх, | ХХААЯ, СЭЗЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 6750.0 | Улсын төсвөөс | 550.0 | 550.0 | 550.0 | 550.0 | 550.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 |
| | | | | Гадаадын зээлээс | 500.0 | 500.0 | 500.0 | | |
| | 6.2 Шинээр 3500 худаг гаргах ажлыг говь, тал, хээрийн бүсийн аймгуудад төвлөрүүлэн зохион байгуулах, | ХХААЯ, СЭЗЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 11250.0 | Улсын төсвөөс | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 500.0 | 1500.0 | 2500.0 | 2500.0 | 3000.0 |
| | 6.3 Цас, борооны усыг хуримтлуулан хиймэл нуур, усан сан, хөв, цөөрөм байгуулах цэгүүдийг тогтоох судалгааны ажил хийх, | ХХААЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 150.0 | Улсын төсвөөс | 30.0 | 30.0 | 30.0 | 30.0 | 30.0 |
| Долоо. Бэлчээрт шинээр уст цэг тогтоож ашиглах замаар бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх | 7.1 Малчдын өвөлжөө, хаваржаанд болон шинээр эзэмших бэлчээр нутагт бага гүнтэй худаг гаргах эрэл хайгуулын ажил хийх, | ХХААЯ, СЭЗЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 310.0 | Улсын төсвөөс | | 50.0 | 80.0 | 80.0 | 100.0 |
| | 7.2 Орон нутаг, иргэдийн оролцоотойгоор 1500-гаас доошгүй гар худаг гаргах ажлыг зохион байгуулах, | ХХААЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 150.0 | Гадаадын тусламжаас | 10.0 | 40.0 | 40.0 | 30.0 | 30.0 |
| | 7.3 Ус өргөх зориулалттай тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх бага оврын цех, туршилт судалгааны төв байгуулахад дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 50.0 | Гадаадын тусламжаас | | 50.0 | | | |
| Найм. Бэлчээрийн хөнөөлт хортон, мэрэгчидтэй тэмцэхдээ байгаль орчинд халгүй арга, технологи хэрэглэх | 8.1 Бэлчээрийн тогтвортой менежментийг бий болгох, бэлчээр сэлгэж хуваарьтай ашиглах, бэлчээрийн даацыг тохируулахэрх зүй, эдийн засгийн орчин бүрдүүлэх, | ХХААЯ, НҮБХХГ | 2600.0 | Гадаадын тусламжаас | 600.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 |
| | 8.2 Жил бүр 550,0 мянган га-гаас доошгүй бэлчээрт үлийн цагаан оготнотой, 50,0 мянган га-гаас доошгүй бэлчээрт царцаатай тэмцэх арга хэмжээг байгаль орчинд халгүй арга, технологиор зохион байгуулах, | ХХААЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 4000.0 | Улсын төсвөөс | 800.0 | 800.0 | 800.0 | 800.0 | 800.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ес. Хадлан тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх | 9.1 Усалгаатай нөхцөлд бэлчээрийн олон наст ургамал тариалах замаар бэлтгэх хадлангийн хэмжээг 40 хувиар, үр үйлдвэрлэлийн хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ, БОЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 2500.0 | Гадаадын тусламжаас | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 |
| | 9.2 Тэжээл тариалах усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ, БОЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 2920.0 | Улсын төсвөөс | 50.0 | 70.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 |
| | 9.3 Тэжээлийн үйлдвэрүүдийг сэргээх, техник, технологийг шинэчлэх ажлыг гадаадын төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | | | x | x | x | x | x |
| | 9.4 Эрчимжсэн мал аж ахуй эрхлэж байгаа фермерүүдийг хүчит тэжээлийн жижиг үйлдвэртэй болоход нь дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 3450.0 | Улсын төсвөөс | 70.0 | 70.0 | 70.0 | 70.0 | 70.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 620.0 | 620.0 | 620.0 | 620.0 | 620.0 |
| Арав. Улс, аймаг, сумын түвшинд гамшгаас хамгаалах бүтэц бий болгон бэхжүүлэх | 10.1 Улс, аймаг, сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийн байршил, тоо, хэмжээг нэмэгдүүлэн түүнд удаан хадгалагдах, уураг, энергийн агууламж өндөртэй тэжээлийн хэмжээг 40 хувьд хүргэх, | ХХААЯ, Гамшгаас хамгаалах байгууллага, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 3150.0 | Улсын төсвөөс | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 | 200.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 | 250.0 |
| | | | | Гадаадын зээлээс | 300.0 | 300.0 | 300.0 | | |
| | 10.2 Улс, аймаг, сумын "Мал хамгаалах сан"-гийн эдийн засгийн чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, менежментийг сайжруулах, | ХХААЯ, Гамшгаас хамгаалах байгууллага, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 3000.0 | Улсын төсвөөс | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 | 300.0 |
| | 10.3 Аймаг дундын отрын нутгийг сэргээн тохижуулж, хамгаалалтад авах, | ХХААЯ | 500.0 | Улсын төсвөөс | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| | 10.4. Улсын нөөцийн өвс, тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх, | | 4700.0 | Улсын төсвөөс | 700.0 | 1000.0 | 1000.0 | 1000.0 | 1000.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Дүн | | 76345.0 | | 14150.5 | 16209.5 | 16441.0 | 14951.0 | 14593.0 |
| | Газар тариалангийн талаар: | | | | | | | | |
| Нэг. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх технологийг боловсронгуй болгох | 1.1 Байгаль, цаг уурын өөрчлөлттэй нөхцөлд газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэх технологийг боловсруулах чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төслийн захиалга өгч, эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх, | ХХААЯ, БСШУЯ | 20.0 | Улсын төсвөөс | 0.0 | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 |
| | 1.2 Улсын нөөцөд үрийн болон тавaарын буудайн нөөцийг зохистой хэмжээнд нэмэгдүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 4600.0 | Улсын төсвөөс | 600.0 | 900.0 | 1000.0 | 1000.0 | 1100.0 |
| | 1.3 "Цомхотгосон болон тэглэх технологи" төсөл боловсруулж тариалан бүхий 3 аймгийн 15 аж ахуйн нэгжид хэрэгжүүлэх, | ХХААЯ, | 330.0 | Гадаадын тусламжаас | 110.0 | 110.0 | 110.0 | | |
| Хоёр. Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх | 2.1 Усалтын системийн менежментийг боловсронгуй болгох замаар ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах, | ХХААЯ | | | х | х | х | х | х |
| | 2.2 Гадаргуугийн урсацыг ашиглан ус хуримтлуулах замаар хадлан, тариалангийн талбайг усжуулах хайгуул, судалгаа явуулж, зураг төсөл боловсруулах, | ХХААЯ | 200.0 | Улсын төсвөөс | 0.0 | 25.0 | 25.0 | 25.0 | |
| | | | | Гадаадын тусламжаас | | 75.0 | 25.0 | 25.0 | |
| | 2.3 Өмчлөгч, эзэмшигчийнх нь захиалгаар 8917 га талбайг услах хүчин чадалтай 19 усалтын системийг сэргээн засварлах зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх, | ХХААЯ, ДБЯ, БОЯ | | Иргэд, хуулийн этгээдийн хөрөнгөөр | х | х | х | х | х |
| | 2.4 13830 га талбайг услах хүчин чадалтай 31 усалтын системийг сэргээн засварлах, | ХХААЯ, ДБЯ, СЭЗЯ | 7853.6 | Улсын төсвөөс | 800.0 | 1000.0 | 1000.0 | 1000.0 | 1000.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 100.0 | 190.0 | 933.6 | 1230 | 600 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Гурав. Инженерийн болон энгийн хийцтэй услалтын системүүдийг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлэх | 3.1 Томоохон услалтын систем байгуулахад шаардлагатай усны нөөцийг нэмэгдүүлэхэд зориулж Сэлэнгэ, Хэрлэнгийн ай савд олон жилийн тохируулгатай усан сан байгуулах хайгуул судалгаа, зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх, | ХХААЯ, ДБЯ, БОЯ, СЭЗЯ | 50.0 | Гадаадын тусламжаас | 20.0 | 30.0 | | | |
| | 3.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн олон жилийн тохируулгатай усан санг Сэлэнгэ, Хэрлэн голын сав дагуу байгуулах асуудлыг шийдвэрлэх, | ХХААЯ, ДБЯ, БОЯ, СЭЗЯ | 2400.0 | Улсын төсвөөс | | | 300.0 | 300.0 | 300.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | | | 250.0 | 250.0 | 250.0 |
| | | | | Гадаадын зээлээс | | | 250.0 | 250.0 | 250.0 |
| | 3.3 28360,0 га талбайг услах хүчин чадалтай 15 услалтын системийг шинээр барих хайгуул, судалгаа, зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх, | ХХААЯ, ДБЯ, БОЯ, СЭЗЯ | 2445.0 | Улсын төсвөөс | | 100.0 | 100.0 | 200.0 | 300.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 100.0 | 200.0 | 100.0 | 100.0 | 150.0 |
| | | | | Гадаадын зээлээс | 170.0 | 425.0 | 125.0 | 137.5 | 237.5 |
| | 3.4 14000 га талбайг услах хүчин чадалтай 11 услалтын системийг шинээр барьж ашиглалтад оруулах, | ХХААЯ, ДБЯ, БОЯ, СЭЗЯ | 15180.0 | Улсын төсвөөс | | | 550.0 | 550.0 | 550.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | | 500.0 | 500.0 | 500.0 | 500.0 |
| | | | | Гадаадын зээлээс | 0.0 | 2430.0 | 1450.0 | 3950.0 | 3700.0 |
| Дөрөв. Нутагшсан сортын үр үйлдвэрлэлийг дэмжиж, дотоодын хэрэгцээг хангах | 4.1 Нутагшсан сортын үрээр дотоодын хэрэгцээг хангах, үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх, | ХХААЯ | 100.0 | Гадаадын тусламжаас | 25.0 | 25.0 | 20.0 | 15.0 | 15.0 |
| | 4.2 Бүсийн тулгуур төвийг түшиглэн ургамлын тос, тэжээл үйлдвэрлэх бага оврын үйлдвэр, цех байгуулах төслийг дэмжих, | ХХААЯ, | 60.0 | Гадаадын зээлээс | 20.0 | 20.0 | 20.0 | | |
| | 4.3 Сэлэнгэ, Хөтөл, Хархорин дахь элеваторыг түшиглэн үрийн болон хүнсний буудайг улсад худалдан авах, борлуулах сүлжээг бий болгох, | ХХААЯ, СЭЗЯ | 0.0 | Хөдөө аж ахуйг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс | x | x | x | x | x |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4.4 Бүс нутгуудад тохирсон жимс, жимсгэний таримал сортын тарьц, суулгац үржүүлэх эх цэцэрлэг, үржүүлгийн газар байгуулж, суулгац материалын хэрэгцээг хангах чиглэлээр иргэд, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх. | ХХААЯ, СЭЗЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 500.0 | Улсын төсвөөс | 20.0 | 20.0 | 10.0 | | |
| | | | | Гадаадын зээлээс | 0.0 | 20.0 | 30.0 | 30.0 | |
| Тав. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй дэвшилтэт технологийг ургамал хамгааллын арга хэмжээнд нэвтрүүлэх | 5.1 Байгаль орчин, бүтээгдэхүүнд сөрөг нөлөөгүй аргаар ургамал хамгаалах шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, ургамлын хорио цээрийн хяналтыг сайжруулж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх замаар таримал ургамлын өвчин хортон, хог ургамлын тархалтыг хязгаарлан ургац нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх, | ХХААЯ, БСШУЯ, УМХГ | 10.0 | Улсын төсвөөс | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 |
| | 5.2 Тухайн жилд тарих үрийн 30-аас доошгүй хувийг ариутгаж тарих, тариалсан талбайн 50-иас доошгүй хувьд гербицид хэрэглэн хог ургамалтай тэмцэх арга хэмжээг зохион байгуулах, ургамал хамгаалах бодисын хангамжийг сайжруулах талаар арга хэмжээ авах, | ХХААЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 400.0 | Гадаадын тусламжаас | 200.0 | 100.0 | 100.0 | | |
| | 5.3 Ургамал хамгааллын үйлчилгээ хийх сум дундын мэргэжлийн аж ахуйн нэгж байгуулж ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 60.0 | Гадаадын тусламжаас | | 30.0 | 30.0 | | |
| Зургаа. Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 6.1 Лизингийн үйлчилгээ нэвтрүүлэх замаар үринш боловсруулалт, тариалалтыг цомхотгосон болон тэг элдэншүүлгээр боловсруулахад зориулагдсан өндөр бүтээмжтэй техникээр газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж байгаа техникийн паркийн 20-25 хувийг шинэчлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 6392.8 | Гадаадын тусламжаас | | 250.0 | 200.0 | 200.0 | 200.0 |
| | | | | Гадаадын зээлээс | | 1500.0 | 1400.0 | 1400.0 | 1242.8 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6.2 Хөдөө аж ахуйн чиргүүл, дүүжин машины зарим эд ангийг /лап, сегментний хадаас, тармуурын шүд г.м/ дотооддоо үйлдвэрлэх, угсрах, засварлахад дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, СЭЗЯ | 200.0 | Гадаадын зээлээс | 50.0 | 50.0 | 50.0 | 50.0 | |
| | 6.3 Өрхийн болон фермерийн аж ахуйд зориулж бага, дунд хүчин чадалтай техник, тоног төхөөремж шинээр авах, лизинг ашиглах ажлыг зохион байгуулах, | ХХААЯ, СЭЗЯ | 2754.5 | Улсын төсвөөс | 350.0 | 450.0 | 400.0 | 400.0 | 400.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 200.0 | 150.0 | 150.0 | 100.0 | 154.5 |
| | 6.4 Газар тариалангийн төвийн бүсэд хөдөө аж ахуйн техник, сэлбэг нийлүүлэх, засвар үйлчилгээ хийх, сургалт явуулах дилерийн төв байгуулах төсөл сонгон шалгаруулж гадаадын хандивлагчдад санал тавих, | ХХААЯ, СЭЗЯ | | | x | x | x | | |
| | 6.5 Цомхотгосон технологийг нэвтрүүлэхэд ашиглах техникийн сорилт, туршилт явуулах төсөл сонгон шалгаруулж, хэрэгжүүлэх | ХХААЯ, БСШУЯ | 50.0 | Улсын төсвөөс | 10.0 | 10.0 | 5.0 | | |
| | | | | Гадаадын тусламжаас | 10.0 | 10.0 | 5.0 | | |
| | 6.6 Төмс, хүнсний ногоог нийлэг хальсан бүрхүүл, хучлага, хэрсгүй орчинд ургуулах, төрөл бүрийн загвар, хийцийн хүлэмж барьж ашиглах талаар сургалт явуулах, хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын төсөл, зээл, тусламжийг чиглүүлэх, | ХХААЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 550.0 | Улсын төсвөөс | 30.0 | 25.0 | 20.0 | 15.0 | 10.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 150.0 | 100.0 | 100.0 | 50.0 | 50.0 |
| **Дүн** | | | **44155.9** | | **3147.0** | **8822.0** | **9385.6** | **11784.5** | **11016.8** |
| | | **Хүнсний үйлдвэрлэлийн талаар:** | | | | | | | |
| Нэг. Уламжлалт цагаан идээ хийхийн зэрэгцээ орон нутагт сүү хүлээн авах, анхан шатны | 1.1 Дотор мах, цус бусад дайвар бүтээгдэхүүн, сүүний уургийн бэлдмэл зэрэг түүхий эдэд тулгуурлан өртөг хямдтай, уламжлалт болон шинэ бүтээгдэхүүний технологи боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, | ХХААЯ, ҮХЯ | 6.0 | Улсын төсвөөс | 3.0 | 3.0 | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| боловсруулалт хийх, хадгалах байгууламжийг бий болгож, хот, суурин газруудад боловсруулах үйлдвэрүүдийг нэмэгдүүлэх | 1.2 Төв суурин газрын хүн амын хэрэгцээг эрүүл ахуйн баталгаатай сүүгээр хангах зорилгоор фермийн аж ахуйд сүү цуглуулах, хөргөх зэрэг анхан шатны боловсруулалт хийх технологи нэвтрүүлэх, | ХХААЯ, УХЯ, Аймаг, нийслэлийн ЗД | 100.0 | Гадаадын зээлээс | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | 1.3 Цөцгийн тос, бяслаг болон удаан хугацаанд хадгалагдах сүүн бүтээгдэхүүний технологийг нэвтрүүлэх, | ХХААЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 100.0 | Улсын төсвөөс | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | 1.4 Уламжлалт цагаан идээг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах арга, технологийн талаархи богино хугацааны сургалтыг бүсчлэн зохион байгуулах, | ХХААЯ | 28.0 | Улсын төсвөөс | 8.0 | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 |
| | 1.5 Улаан буудайнаас бусад үр тариагаар өргөн хэрэглээний болон тусгай зориулалтын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи боловсруулах төслийг шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлэх арга хэмжээ авах, | ХХААЯ, БСШУЯ | 16.0 | Улсын төсвөөс | 4.0 | 3.0 | 3.0 | 3.0 | 3.0 |
| | 1.6 Байгалийн болон таримал жимс, жимсгэнэ боловсруулах үйлдвэрлэлийг бий болгож, Хөвсгөл, Архангай, Булган, Өвөрхангай, Хэнтий, Завхан, Увс Дархан-Уул, Сэлэнгэ аймагт энэ чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулах, | ХХААЯ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд, Аймгийн ЗДТГ | 20.0 | Улсын төсвөөс | 4.0 | 4.0 | 4.0 | 4.0 | 4.0 |
| | 1.7 Төмс, хүнсний ногоо боловсруулах, хадгалах дэвшилтэт арга, технологийг судлан нэвтрүүлэх, | ХХААЯ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 25.0 | Улсын төсвөөс | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 | 5.0 |
| | 1.8 Хөвсгөл аймгийн Цагааннуур, Рэнчинлхүмбэ сумын загас агнуурын аж ахуйг сэргээхэд дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, БОЯ, Аймгийн ЗДТГ | 60.0 | Улсын төсвөөс | 20.0 | 20.0 | 20.0 | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.9 Хиймэл цөөрөм байгуулж загас үржүүлэхэд дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, БОЯ | 50.0 | Гадаадын тусламжаас | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 |
| Хоёр. Сувиллын үйлчилгээтэй хоол тэжээл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нэр төрлийг нэмэгдүүлэх | 2.1 Жимс, хүнсний ногоог орчны агаарын найрлагыг тохируулан өөрчлөн хадгалах, сав, баглаа боодлын технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, | ХХААЯ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 105.0 | Гадаадын зээлээс | 25.0 | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | 2.2 Хүүхдийн болон сувиллын хоол тэжээл, хүнсний бүтээгдэхүүний жор, технологийг боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, | ХХААЯ, ЭМЯ | 50.0 | Улсын төсвөөс | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 |
| | | | 100.0 | Гадаадын тусламжаас | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | | | 75.0 | Гадаадын зээлээс | 15.0 | 15.0 | 15.0 | 15.0 | 15.0 |
| Гурав. Хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох | 3.1 Хүнсний үйлдвэрүүдийг олон улсын түвшинд чанарын удирдлагын системээр үнэлэх арга зүйг судлах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх төсөл боловсруулах, | СХЗТ, ХХААЯ | 35.0 | Гадаадын тусламжаас | 20.0 | 15.0 | | | |
| | | | 30.0 | Гадаадын зээлээс | 15.0 | 15.0 | | | |
| | 3.2 Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих дотоодын хяналтыг боловсронгуй болгож, лабораторийн хяналт шинжилгээг олон улсын жишигт хүргэх, | ХХААЯ, СХЗТ, УМХГ | 50.0 | Улсын төсвөөс | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 |
| | 3.3 Архи, спиртийн үйлдвэрүүдийг тоолууржуулах ажлыг бүрэн хэрэгжүүлэх, | ХХААЯ, ҮХЯ, ХЗДХЯ, СЭЗЯ | 0.0 | Хөдөө аж ахуйг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс | x | | | | |
| Дөрөв. Хот суурин газрын хүн амыг эрүүл ахуй, ариун цэврийн аюулгүй | 4.1 Төвлөрсөн хот суурин газарт борлуулах махны стандартыг шинэчлэх, | ХХААЯ, СХЗТ, УМХГ | 0.0 | Хөдөө аж ахуйг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс | x | x | x | x | x |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| нөхцөлд бэлтгэгдсэн махаар хангаж үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж, мах, махан бүтээгдэхүүний боловсруулалтын чанарыг дэлхийн жишигт хүргэж, экспортыг нэмэгдүүлэх | 4.2 Мал бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгох. | ХХААЯ | 0.0 | Хөдөө аж ахуйг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс | | x | x | x | x |
| | 4.3 Мах судлалын лаборатори байгуулах. | ХХААЯ | 500.0 | Гадаадын зээлээс | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| | 4.4 Махыг вакум аргаар савлах, бүрэн утлагат хиам, бусад бэлэн бүтээгдэхүүний шинэ технологи нэвтрүүлж, экспортыг нэмэгдүүлэх. | ХХААЯ, ҮХЯ | 150.0 | Гадаадын тусламжаас | 100.0 | 50.0 | | | |
| | 4.5 Гадаадын зах зээлд монгол малын мах, махан бүтээгдэхүүнийг сурталчилж, борлуулах. | ХХААЯ, ҮХЯ, МХАҮТ | 30.0 | Гадаадын зээлээс | 30.0 | | | | |
| Тав. Стратегийн болон импорт орлох экспортын хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл , үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх | 5.1 Экологийн цэвэр түүхий эд, биологийн идэвхит хүнсний бүтээгдэхүүний боловсруулалт, үйлдвэрлэлийг дэмжих. | ХХААЯ, ҮХЯ | 125.0 | Улсын төсвөөс | 25.0 | 25.0 | 25.0 | 25.0 | 25.0 |
| | 5.2 Загасны салбарын удирдлагын чадавхийг нэмэгдүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх. | ХХААЯ, БОЯ, Аймгуудын ЗДТГ | 70.0 | Гадаадын зээлээс | 35.0 | 35.0 | | | |
| | 5.3 Гол мөрөн, цэнгэг нуурын загасыг утах, хөлдөөх, хатаах, нөөшлөх, давслах технологи боловсруулж загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, экспортлох. | ХХААЯ, ҮХЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 65.0 | Гадаадын тусламжаас | 35.0 | 30.0 | | | |
| | 5.4 Спирт, цагаан архины технологийг боловсронгуй болгон зах зээлийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох арга хэмжээг хэрэгжүүлэх. | ХХААЯ, ҮХЯ | 0.0 | Хөдөө аж ахуйг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс | x | x | x | x | x |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 5.5 Цэвэр ус, рашааны стандартыг шинэчлэн тогтоож, үйлдвэрлэлд мөрдүүлэх, | ХХААЯ, УХЯ, СХЗТ, Аймгийн ЗДТГ | 0.0 | Хөдөө аж ахуйг хөгжүүлэх сангийн хөрөнгөөс | x | x | x | x | x |
| | 5.6 Улсын нөөцийн хүнсний барааны хэмжээг нэмэгдүүлэх | ХХААЯ, СЭЗЯ | 2190.0 | Улсын төсвөөс | 340.0 | 350.0 | 500.0 | 500.0 | 500.0 |
| Зургаа. Амьтан, ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүний боловсруулалт, сав, баглаа боодлыг сайжруулж хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлийг боловсронгуй болгох | 6.1 Байгалийн болон таримал жимс, жимсгэнэ, хүнсний ногоог нөөшлөх, хатаах үйл ажиллагааг өргөжүүлэх, | ХХААЯ, УХЯ, Аймгийн ЗДТГ | | | x | x | x | x | x |
| | 6.2 Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний маркетингийн урамшуулалт арга ажиллагааг нэвтрүүлж, өргөжүүлэх, | УХЯ, ХХААЯ, СЭЗЯ | 100.0 | Гадаадын тусламжаас | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | 6.3 Мах, сүү, цагаан идээний борлуулалтын зохистой сүлжээг бий болгох, | ХХААЯ, УХЯ, Аймгийн ЗДТГ | | | x | x | x | x | x |
| | Дүн | | 4080.0 | | 894.0 | 805.0 | 807.0 | 787.0 | 787.0 |
| **Хүнс, хөдөө аж ахуйн салбарт шинжлэх ухаан, технологийн ололт нэвтрүүлэх талаар:** | | | | | | | | | |
| Нэг. Салбарын хүрээнд хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслүүдийн чанар, үр дүнг дээшлүүлэх | 1.1 Эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага болон үйлдвэрлэгчийн уялдаа холбоог сайжруулах замаар шинжлэх ухаан, технологийн төслийн захиалга, үр дүнг хүлээн авах, үйлдвэрлэлд шилжүүлэх тогтолцоог боловсронгуй болгох, | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 0.0 | | x | x | x | x | x |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.2 Онош нь тогтоогдоогүй малын зарим өвчний шалтгааныг тогтоох, эмчлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 60.0 | Улсын төсвөөс | 20.0 | 10.0 | 10.0 | 10.0 | 10.0 |
| | 1.3 Монгол орны цаг агаарын нөхцөлд тохирсон, богино хугацаанд боловсордог, ган, хүйтэнд тэсвэртэй үр тарианы болон тэжээлийн таримлыг нутагшуулах, шинэ сорт бий болгох төсөл боловсруулж шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлэх арга хэмжээ авах, | ХХААЯ, БСШУЯ | 20.0 | Улсын төсвөөс | 4.0 | 4.0 | 4.0 | 4.0 | 4.0 |
| | 1.4 Монгол малын удам зүйн үзүүлэлтүүдийг шинэчлэн тодорхойлж, ган, зудыг тэсвэрлэх чадвар, ашиг шимийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах селекци-генетикийн аргыг боловсруулж хэрэгжүүлэх, | ХХААЯ, БСШУЯ, ДБЯ | 60.0 | Улсын төсвөөс | 10.0 | 20.0 | 10.0 | 10.0 | 10.0 |
| | 1.5 Салбарын эрдэм шинжилгээний байгууллагын ажилтнуудыг өндөр хөгжилтэй орнуудын ижил төрлийн байгууллагад мэргэжил дээшлүүлэх, биотехнологи, генийн инженерчлэлийн чиглэлээр магистр, докторантурт суралцуулах, | БСШУЯ, ХХААЯ, ХААИС | 40.0 | Гадаадын зээлээс | 8.0 | 8.0 | 8.0 | 8.0 | 8.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хоёр. Салбарын эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжилтнүүдийг үйлдвэрлэгчидтэй холбох, тэдний хамтын ажиллагаа, үр дүнг дээшлүүлэх | 2.1 Салбарын эрдэм шинжилгээний байгууллагуудын шинжилгээ, судалгааны техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх, | ГХЯ, ХХААЯ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 100.0 | Гадаадын зээлээс | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | 2.2 Үйлдвэрлэгчийн захиалгаар шинжлэх ухаан, технологийн төслийг тухайн аж ахуйг түшиглэн хэрэгжүүлж, үр дүнг хамтран нэвтрүүлэх хэлбэрийг турших, | БСШУЯ, ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 0.0 | | x | x | x | x | x |
| | 2.3 Салбарын тэргүүлэх мэргэжилтэн, эрдэмтдийг үйлдвэрлэгчтэй холбох, зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах, | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 0.0 | | x | x | x | x | x |
| | 2.4 Шинэ технологи нэвтрүүлэх ажлыг хоёр буюу гурвалсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэж, үр ашгийг хамтран хүртэх хэлбэрт шилжүүлэх, | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 0.0 | | x | x | x | x | x |
| Гурав. Хөдөө аж ахуйн сургалт нэвтрүүлэлтийн | 3.1 Хөдөө аж ахуйн сургалт нэвтрүүлэлтийн /экстейншиний/ үйлчилгээг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулах, | ХХААЯ, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 591.4 | Гадаадын тусламжаас | 191.4 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйлчилгээг өргөжүүлж, үйлдвэрлэгчдэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх ажлыг өргөжүүлэх | 3.2 Аймаг бүрт сургалт нэвтрүүлэлтийн /экстейншиний/ алба байгуулж материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэшсэн ажилтнууд бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх, | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 769.0 | Гадаадын тусламжаас | 169.0 | 150.0 | 150.0 | 150.0 | 150.0 |
| | 3.3 Малчид, тариаланчдыг эдийн засаг, зах зээлийн мэдлэгтэй болгох, аж ахуйгаа шинжлэх ухааны үндэстэй эрхлэх арга ажиллагаанд сургах талаар сургалтын дэд төсөл боловсруулж хэрэгжүүлэх, | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 1.5 | Улсын төсвөөс | 1.5 | | | | |
| | 3.4 Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан эрхлэх иргэд, аж ахуйн нэгжид төсөл, бизнес төлөвлөгөө боловсруулахад туслах, үйлдвэрлэлийн явцад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх ажлыг өргөжүүлэх, | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 3.5 | Улсын төсвөөс | 2.0 | 1.5 | | | |
| | 3.5 Олон нийтийн болон зайны сургалтын мэдээллийн хэрэгсэл, аудио болон видео хэрэгслийг ашиглан үйлдвэрлэгчдэд мэдээлэл, мэдлэг түгээх тогтолцоо бий болгох, | ХХААЯ, БСШУЯ, РТХЭГ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 3.0 | Улсын төсвөөс | 2.0 | 1.0 | | | |
| | 3.6 Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, загас боловсруулах, хадгалах дэвшилтэт арга технологи, техникийг судлан нэвтрүүлэх, | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 10.0 | Улсын төсвөөс | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 |
| Дөрөв. Салбарын мэргэжилтэн, ажилтнуудын боловсрол, мэдлэгийн чадварыг дээшлүүлэх | 4.1 Салбарын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгож өндөр хөгжилтэй орны жишигт ойртуулах, | ХХААЯ, БСШУЯ, ХААИС | 0.0 | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 4.2 Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчныг давтан сургах, мэргэшүүлэх тогтолцоо бий болгох. | ХХААЯ, БСШУЯ, ХААИС, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 100.0 | Гадаадын зээлээс | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 | 20.0 |
| | 4.3 Хоршооны сургалт, мэдээллийн төвийг орон нутагт байгуулах, техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | ХХААЯ, СЭЗЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ | 170.0 | Гадаадын тусламжаас | 70.0 | 25.0 | 25.0 | 25.0 | 25.0 |
| | 4.4 Малын хээрэл үрийг шилжүүлэн суулгах, гүн хөлдөөх, микроманипуляцийн аргаар хуваах, түүний чанар, хүйсийг тодорхойлох, өндгөн эсийг /ооцит/ олноор гадагшлуулах, ялган авах, "инвитро" нөхцөлд үр тогтоох арга технологи бий болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх. | ХХААЯ, Холбогдох эрдэм шинжилгээний байгууллагууд | 75.0 | Гадаадын тусламжаас | 50.0 | 25.0 | | | |
| Дүн | | | 2003.4 | | 569.9 | 386.5 | 349.0 | 349.0 | 349.0 |
| БҮГД ДҮН | | | 127434.3 | | 19611.4 | 26223.0 | 26982.6 | 27871.5 | 26745.8 |
| ҮҮНЭЭС /сая төг/ | | | | Улсын төсвөөс | 11811.0 | 11798.0 | 12641.0 | 12199.0 | 11781.0 |
| | | | | Гадаадын тусламжаас | 6472.4 | 8927.0 | 9993.6 | 9632.0 | 9311.5 |
| | | | | Гадаадын зээлээс | 1328.0 | 5498.0 | 4348.0 | 6040.5 | 5653.3 |
| БҮГД ДҮН | | | | 127434.3 | 19611.4 | 26223.0 | 26982.6 | 27871.5 | 26745.8 |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.

Улаанбаатар- 12
Төрийн ордон
☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487
Хэвлэлийн хуудас 3